

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/92/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: А.Оюундэлгэр Утас: 99306289 цахим хаяг: a_oyund@yahoo.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.4 Зөвлөмж .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮЕНЧ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Т.ТОГТОХБАЯР ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.25 № 02/23  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>34,142,471</u></b>	<b><u>40,635,826</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,738,993	7,848,368
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,062,106	2,062,106
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	676,887	5,786,262
3351	Байгууллагаас авах авлага	676,887	5,786,262
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	31,403,478	32,787,458
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	27,254,286	27,254,386
35110	Тусгай зориулалттай материал	26,254,286	26,254,286
35130	Эм боох материал	1,000,000	1,000,100
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,149,192	5,533,072
35460	Хүнсний материал	3,274,792	4,588,672
35470	Бусад хангамжийн материал	874,400	874,400
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>803,518,516</u></b>	<b><u>908,713,955</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	803,518,516	908,713,955
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	791,518,516	896,713,955
39201	Барилга, байгууламж, орон сууц	751,469,412	878,469,412
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,790,936	-29,589,150
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,208,451	38,208,451
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,354,346	-31,741,821
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,459,272	70,459,272
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,285,440	-36,464,511
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,396,023	9,396,023
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,698,207	-5,168,008
39217	Ном	3,114,288	3,144,288
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12,000,000	12,000,000
39301	Програм хангамж	198,432	198,432
39302	Хуримтлагдсан элэгдэл	-198,432	-198,432
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000	12,000,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>837,660,987</u></b>	<b><u>949,349,782</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>837,660,987</u></b>	<b><u>949,349,782</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	837,660,987	949,349,782
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,504,224	122,504,224
51101	Өмч: - төрийн	122,504,224	122,504,224
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	341,575,513	453,264,307
51210	Өмнөх үеийн үр дүн	341,575,513	341,575,513
51220	Тайлант үеийн үр дүн	00	111,688,794
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	373,581,251	373,581,251
<b>6</b>	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>837,660,987</u></b>	<b><u>949,349,782</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>536,543,630</b>	<b>593,672,692</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>108,141,630</b>	<b>127,000,000</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	108,141,630	127,000,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	108,141,630	127,000,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	108,141,630	127,000,000
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>22,848,400</b>	<b>44,662,792</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,553,600	422,009,900
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00	10,688,512
131104	Дээд шагны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	10,688,512
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>22,848,400</b>	<b>28,412,400</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,848,400	28,412,400
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00	5,561,880
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00	5,561,880
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>445,744,426</b>	<b>481,983,898</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>445,744,426</b>	<b>481,983,898</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>433,934,256</b>	<b>434,329,830</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>306,427,578</b>	<b>305,558,563</b>
210101	Үндсэн цалин	304,626,834	302,005,888
210102	Нэмэгдэл	1,800,744	3,552,675
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,476,646</b>	<b>38,775,319</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,476,646	38,775,319
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,223,400</b>	<b>26,843,950</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,338,284	2,177,650
210302	Түлш, халаалт	22,591,116	24,633,000
210303	Цэвэр, бохир ус	294,000	33,300
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,768,200</b>	<b>2,566,618</b>
210401	Бичиг хэрэг	197,400	124,600
210402	Тээвэр, шагахуун	1,069,600	1,195,500
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,300	87,200
210404	Ном, хэвлэл	57,700	20,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00	863,368
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	331,200	275,650
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,714,945</b>	<b>27,495,770</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,209,500	398,650
210502	Хоол, хүнс	34,950,745	26,409,620

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,554,700	687,500
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00	182,000
210604	Урсгал засвар	00	182,000
<b>2108</b>	<b>Буслаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	200,000	790,400
210801	Буслаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	54,400
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	522,000
210807	Газрын төлбөр	00	214,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,123,487	32,117,211
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00	5,995,300
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,631,600	4,287,350
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,491,887	21,834,561
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,810,170	47,654,067
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00	15,387,024
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00	5,561,880
213208	Ходөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	9,825,144
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11,810,170	32,267,043
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,810,170	32,267,043
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>90,799,204</b>	<b>111,688,794</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>90,799,204</b>	<b>111,688,794</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	341,575,513	837,660,987
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	341,575,513	837,660,987
D03	Дахин н.гэрхийлсэн үлдэгдэл	122,504,224	373,581,251	341,575,513	837,660,987
D08	Тайлант үеийн үр дүн	00	00	111,688,794	111,688,794
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	453,264,307	949,349,782

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>428,402,000</b>	<b>466,672,692</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>428,402,000</b>	<b>466,672,692</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,553,600	422,009,900
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00</b>	<b>10,688,512</b>

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	10,688,512
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>22,848,400</b>	<b>28,412,400</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,848,400	28,412,400
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>00</b>	<b>5,561,880</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00	5,561,880
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>428,402,000</b>	<b>466,672,692</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>428,402,000</b>	<b>466,672,692</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>416,591,830</b>	<b>419,018,625</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>307,876,788</b>	<b>305,827,121</b>
210101	Үндсэн цалин	199,856,262	188,330,036
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00	00
210104	Урамшуулал	23,549,588	21,533,607
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,889,542</b>	<b>43,616,136</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,563,442	29,249,650
210202	Тэтгэмжийн даатгал	3,081,500	3,078,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,465,200	2,463,120
210204	Ажилгүйдлийн даатгал	616,300	615,780
210205	Эрүүл мэндийн даатгал	6,163,100	8,208,686
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,623,400</b>	<b>28,230,300</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,338,284	3,197,300
210302	Түлш, халаалт	19,991,116	24,633,000
210303	Цэвэр, бохир ус	294,000	400,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,645,700</b>	<b>2,464,468</b>
210401	Бичиг хэрэг	136,700	117,600
210402	Тээвэр, шатахуун	1,069,600	1,069,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,300	99,800
210404	Ном, хэвлэл	78,100	57,600
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00	863,368
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,000	256,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,400,900</b>	<b>26,505,300</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,201,500	1,173,000
210502	Хоол, хүнс	36,758,100	24,639,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,441,300	693,300
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>180,000</b>	<b>182,100</b>
210604	Урсгал засвар	180,000	182,100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00</b>	<b>125,900</b>
210702	Догоод албан томилолт	00	125,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>312,000</b>	<b>717,400</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,000	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	573,800
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,663,500</b>	<b>11,349,900</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00	4,300,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,663,500	7,049,900
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,810,170</b>	<b>47,654,067</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00</b>	<b>15,387,024</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00	5,561,880
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	9,825,144
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11,810,170</b>	<b>32,267,043</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,810,170	32,267,043

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	450,402,800	418,155,257
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	450,402,800	418,155,257
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	450,402,800	418,155,257
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	313,900,200	305,827,121
210101	Үндсэн цалин	189,232,800	188,330,036
210102	Нэмэгдэл	104,023,800	95,963,478
210104	Урамшуулал	20,643,600	21,533,607
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,376,500	43,616,136
210201	Тэтгэврийн даатгал	29,820,600	29,249,650
210202	Тэтгэмжийн даатгал	3,139,000	3,078,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,511,100	2,463,120
210204	Ажилгүйдлийн даатгал	627,800	615,780
210205	Эрүүл мэндийн даатгал	6,278,000	8,208,686
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,230,300	28,230,300
210301	Гэрэл, цахилгаан	3,197,300	3,197,300
210302	Түлш, халаалт	24,633,000	24,633,000
210303	Цэвэр, бохир ус	400,000	400,000
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,581,600	1,601,100
210401	Бичиг хэрэг	121,500	117,600
210402	Тээвэр, шатахуун	1,069,600	1,069,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	99,800	99,800
210404	Ном, хэвлэл	69,400	57,600

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	221,300	256,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,206,800</b>	<b>26,505,300</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,200	1,173,000
210502	Хоол, хүнс	55,440,300	24,639,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693,300	693,300
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>182,100</b>	<b>182,100</b>
210604	Урсгал засвар	182,100	182,100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>125,900</b>	<b>125,900</b>
210702	Дотоод албан томилолт	125,900	125,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний толбор, хураамж</b>	<b>719,600</b>	<b>717,400</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний толбор хураамж	143,600	143,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000	573,800
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,079,800</b>	<b>11,349,900</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,100,000	4,300,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дашига хийх	3,979,800	7,049,900
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>450,402,800</b>	<b>418,155,257</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>421,990,400</b>	<b>389,742,857</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	421,990,400	389,742,857
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,412,400</b>	<b>28,412,400</b>
132001	Орон нутгийн төсвөөс	28,412,400	28,412,400
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26</b>	<b>32</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	18
620003	Үйлчлэх ажилтан	6	10
650010	Гэрээт ажилтан	3	3

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>16,250,392.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,250,392.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>16,250,392.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>863,368.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	863,368.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,561,880.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,825,144.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>16,250,392.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,250,392.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,250,392.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Үенч сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд и баримт, үндсэн хөрөнгө, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Оюундэлгэр 2022 оны 02 дугаар сарын 11-нээс 2022 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үенч сумын хүүхдийн цэцэрлэг нь сумын 2-5 насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулж цэцэрлэгийн хамран сургалтыг 0,5 хувиар ахиулж, үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах, Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол, шийдвэр, аймаг суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгон ажиллаж байгаа сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тус байгууллага нь 2021 онд "Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

*Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2019 оноос шинэчлэгджээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлогын 461,1 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 9,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үенч сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111.7 сая төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд 5.1 сая төгрөгийн авлага шинээр үүссэн байна. ХАОАТ 5,1 сая төгрөгийг илүү төлсөн байна. Бараа материалын дансны эхний үлдэгдэл 31.4 сая төгрөгөөс 32,7 сая төгрөг болж 1,3 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 39.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 37,6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 884,8 сая төгрөг, оны эцэст 908,7 сая төгрөг болж 23,9 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 110.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн, дэлхийн зөн орон нутгийн хөгжлийн сангаас 17.0 сая төгрөгөөр хашаа шинэчилсэн. Төсвийн хөрөнгөөр 0.03 сая төгрөгийн ном авсантай холбоотой нэмэгдэж, мөн тайлант хугацааны хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой буурсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгө бэлтгэж, акталсан зүйл байхгүй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 837,6 сая төгрөг байсан оны эцэст 949 сая төгрөг болж тайлант онд 111.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 453.2 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Үенч сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 492.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 492.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 492,5 сая төгрөгөөр батлан ирүүлж, тайлант хугацаанд төсвийн тодотгол нэг удаа хийгдэж 450.4 сая төгрөг болж 42,1 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 422.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 28,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 418,1 сая төгрөгийг зарцуулж 32,3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 418,1 сая төгрөг буюу 92,8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 6,8 сая төгрөгөөр, нормативт зардлыг 25,5 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 9,8 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 5,5 сая төгрөгийн санхүүжилт ирснээс 5 жилийн тэтгэмжийг 2 ажилтанд, листийг 3 ажилтанд 15,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг зардлын зүйл бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 65 мэдээллийг хугацаандаа мэдээлж 86 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын 100 хувь хэрэгжүүлсэн. Нягтлан бодогч солигдсон өмнө ажиллаж байсан нягтлан бодогч ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүйгээс хэрэгжилт 50 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 9.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй.

### **4.2 Төлбөрийн акт**

Байгууллагын төсвөөс 5.1 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг илүү шилжүүлж авлага үүсгэсэн нь Засгийн газрын 43 тоот тогтоолоор төвлөрөх төсвийн хэмнэлтийг зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **4.4.1 Засгийн газрын тогтоолын хэрэгжилтэй холбоотой асуудал**

**4.1 Илрүүлэлт:** Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.10.01-ний өдрийн А/29 тоот тушаалаар постод хоол өгсөн 1.3 сая төгрөг, хоолонд тансаг хэрэглээ 1.7 сая төгрөгийн алим, мандарин, усан үзэм, майонез хэрэглэсэн байна

**4.1 Өгсөн зөвлөмж:** “Хүүхдийн хоол хүнсэнд хориглосон бүтээгдэхүүн хэрэглэх асуудлыг таслан зогсоож, хүүхдийн хоолны илч норм тооцон ажиллах.

#### **4.4.2 Авлага данстай холбоотой асуудал**

**4.2 Илрүүлэлт:** Байгууллагын тайланд хувь иргэнээс авах 2.1 сая төгрөг, бусад 0.6 сая, нийт 2.7 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа ч тооцоо нийлсэн актаар баталгаажуулж он дамжин үлдэгдэлтэй бүртгэгдсэн, авлагын эзэн холбогдогч нь тодорхой бус байна.

**4.2 Өгсөн зөвлөмж:** Авлагыг тооцоо нийлсэн үлдэгдлээр баталгаажуулан эзэн холбогдогчийг тогтоон авлагыг барагдуулан ажиллах

#### **4.4.3 Үндсэн хөрөнгийн тооллого тооцоотой холбоотой асуудал**

4.3 Илрүүлэлт: Хөрөнгийн тооллогоор 144 нэрийн 2.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 48 нэрийн 5.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 192 нэр төрлийн 7.6 сая төгрөгийн хөрөнгө актлахаар судалгааг хийсэн.

4.3 Өгсөн зөвлөмж :Үндсэн хөрөнгийн бүртгэлд дотоод хяналт хэрэгжүүлэн, дээд шатны байгууллагаар шийдвэрлэн, хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр үнэн зөв хийж, бүртгэлд тусгах

4.4.4 Шилэн дансны хуультай холбоотой асуудал

4.4 Илрүүлэлт : 32 мэдээ 401.9 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцорсон. 32 нь 1, 4, 6,7,9,10,11 сард хоцорсон

4.4 Өгсөн зөвлөмж: “ Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
1	Үенч сумын хүүхдийн цэцэрлэг	5	17.8	0	0.0	1	5.1	0	0	4	7.6


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ХО ӨРЛӨГИЙН ҮРС АУДИТ ХХК-НЫ ЗАХИРАЛ

АУДИТОР:  А.ОЮУНДЭЛГЭР